

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ, ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2020 ОНЫ 3 ДУГААР САРЫН МЭДЭЭ

Нэг. Удирдлага, зохион байгуулалтын талаар:

Аймгийн Засаг дарга Өвөлжилт хүндрэлтэй суманд ажиллаж нөхцөл байдалтай газар дээр нь танилцав. Энэ үеэр аймгийн Засаг даргын санаачилсан “Итгэл сэтгэл” аянд нэгдсэн төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуй нэгжүүдийн малчдаа туслах хандивыг малчдад хүргэн ажилласан.

Төрийн байгууллагууд аймгийн засаг даргын А/161 дугаар захирамжаар жирэмсэн болон 0-12 насны хүүхэдтэй эмэгтэй албан хаагчдыг хорогдуулсан цагаар ажиллуулах тухай шийдвэрийг гарган хэрэгжүүлэн ажиллаж байна. Аймгийн Онцгой комиссын 2020 оны 01 дүгээр албан даалгавараар аймгийн хэмжээнд 24 сум, 75 байгууллагын удирдлагууд албан ёсны тушаал, шийдвэр гаргаж, 0-5 хүртэлх насны хүүхэдтэй 1205 албан хаагч 2020 оны 30 дугаар сарын 30-наас өдрөөс 4 дугаар сарын 30-ний өдөр хүртэл богиносгосон цагаар ажиллуулж байна.

Хөвсгөл аймаг 2020 оныг "Зүтгэл-Итгэл-Санаачилга"-ыг дэмжих жил болгон зарласан. Нэрлэсэн жилийн ажлыг эрчимжүүлэх, төрийн албан хаагчид, иргэд нийтийн оролцоог хангах зорилгоор нэрлэсэн жилийн тугийг төрийн байгууллага, сумдад ажлын 7 хоногийн хугацаатай хуваарийн дагуу өртөөчлөн аялуулах ажлыг эхлүүллээ.

Туг аялах явцад сумд, агентлаг, байгууллагууд нэрлэсэн жилийн захирамжийн хэрэгжилтийг хангах, зохион байгуулагдаж байгаа болзолт уралдаануудыг иргэдэд хүргэх, инноваци шингэсэн бүтээлч ажил санаачилж, үр дүнг олон нийтэд мэдээллэх, тугийг хуваарийн дагуу дараагийн байгууллага, суманд шилжүүлэх, ажлын тайланг гаргах зэрэг ажлуудыг хэрэгжүүлэх юм байна.

Хоёр. Эдийн засаг, төсөв, санхүүгийн бодлогын хүрээнд:

Төрийн сангийн төлбөр тооцооны программаар 2020 оны 03-р сард 46 Төсөвт байгууллагын үндсэн болон нэмэлт санхүүжилтийн данснаас 13.0 тэрбум төгрөгний **1.828** ширхэг гүйлгээ шивэгдсэн байна.

Төсвийн гүйцэтгэлийн 2020 оны 2-р сарын мэдээгээр Орон нутгийн орлого, санхүүжилт 9,829.0 сая төгрөгний төлөвлөгөөтэйгээс 9,285.7 сая төгрөг буюу 94.5 хувийн гүйцэтгэлтэй байна.

Орон нутгийн болон тусгай шилжүүлгийн байгууллагуудын төсвийн зарлагын гүйцэтгэл батлагдсан төсөв 22.888,0 сая төгрөг байгаа бөгөөд үүнээс 10.629,7 сая төгрөг нь тусгай зориулалтын шилжүүлгээс, 3.541,1 сая төгрөг нь орон нутгийн байгууллагуудад олгох санхүү дэмжлэг болон аймаг сумын орлогоос, 84,6 сая төгрөг нь төсөвт байгууллагын өөрийн орлогоос, 400,1 сая төгрөг нь орон нутгийн хөгжлийн

нэгдсэн сангаас тус тус санхүүжигдсэн байна. Төсвийн гүйцэтгэлийн мэдээнд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр 22.888,0 сая төгрөг, зарлагын гүйцэтгэл 16.419,5 мянган төгрөг буюу 71,7 % хувьтай байна. ТЗШ-ын санхүүжилт болон санхүүгийн дэмжлэг бүрэн ирсэн. ОНХС-ийн санхүүжилт дутуу ирсэн. Үндсэн үйл ажиллагааны орлого өндөр давалттай байна..

Төсвийн гүйцэтгэлийн мэдээгээр Төсвийн нийт авлага **4.908,0** сая төгрөг өмнөх сараас **92.9** сая төгрөгөөр өссөн байна.

Нийт өглөг **915,6** сая төгрөг өмнөх сараас 123,6 сая төгрөгөөр өссөн байна.

Нийгмийн даатгалын хэлтэсийн сарын шуурхай мэдээ:

2020 оны 03 дугаар сарын байдлаар нийгмийн даатгалын санд шимтгэлийн орлого 2695.3 сая төгрөг, сайн дурын даатгуулагчаас 202.1 сая төгрөгийн, шимтгэлийн орлого 94.8 хувиар биелүүлсэн байна.

Төлөвлөгөөг сан тус бүрээр нь харуулбал:

/Сая.төг/

Төрөл	төлөвлөгөө	Гүйцэтгэл	хувь
Тэтгэвэр	2562.6	2462.8	96.1
Тэтгэмж	294.1	260.8	88.0
Үомшө	150.2	115.9	77.2
ЭМД	0,0	0,0	0,0
ажилгүйдэл	50.1	57.9	115.6
дүн	3057	2897.4	94.8

Тэтгэврийн даатгалын сангаас 19245 тэтгэвэр авагчид 13355.8 сая төгрөгийн 4 төрлийн тэтгэвэр, тэтгэмжийн даатгалын сангаас 493 даатгуулагчдад 393.1 сая төгрөгийн тэтгэмжийн зардал, ажилгүйдлийн даатгалын даатгалын сагаас 53 даатгуулагчдад 105.3 сая төгрөгийн ажилгүйдлийн тэтгэмж олгосон байна. Нийгмийн даатгалын шимтгэлийн авлага 340.2 сая төгрөг байна.

Гурав. Хууль эрхзүйн бодлогын хүрээнд :

Цагдаагийн байгууллагатай хамтран аймгийн хэмжээнд 38 сүм, хийд, шашны байгууллагуудын үйл ажиллагаанд төлөвлөгөөт бус шалгалт хийсэн. , шашны чиглэлээр үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийг шалгахад 17 байгууллага зөвшөөрөлгүй шашны үйл ажиллагаа явуулж байсныг илрүүлж, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хуралд үйл ажиллагааг зогсоох саналыг хүргүүлж нэг шашны байгууллагад Зөрчлийн тухай хуулиар торгуулийн арга хэмжээ авч ажилласан.

“Мөсөн замын тээвэрлэлтийг хориглох тухай” аймгийн Засаг даргын А/110 захирамж гаргуулж, сумдын Засаг дарга нарт 24 цагийн хяналт шалгалтыг зохион байгуулах үүрэг чиглэл өгч, захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллаж байна.

Нийтийн эзэмшлийн зам талбай хог хаягдлыг түр цэгүүд орон сууцны орц хонгил, хана тааз, шат цонхыг цэвэрлэж мэргэжлийн байгууллагаар ариутгал халдваргүйтгэлийг хийлгэх ажлыг зохион байгуулах зөвлөмжийг Мөрөн сумын ЗДТГ-т өгснөөр “Эрүүл Мөрөн хот” аяныг санаачлан зохион байгуулж 25 байр, 85 орц, 5 пудволд цэвэрлэгээ хийж, 3233 м2 талбайд ариутгал халдваргүйтгэлийг хийсэн.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр

Аймгийн Засаг даргын Захирамжаар 2020 оны 02 дугаар сарын 27-ны өдрөөс 03 дугаар сарын 31-ны өдөр хүртэл хугацаанд аймгийн хэмжээнд согтууруулах ундаагаар үйлчлэхийг бүрэн зогсоож хяналт тавьж ажилласнаар гэмт хэрэг, зөрчил 63%-аар буурсан үзүүлэлттэй байна.

Дээрх хугацаанд зөрчил гаргасан 6 согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй дэлгүүрүүдэд ажлын хэсэг томилогдон ажиллаж тусгай зөвшөөрлийг туслах арга хэмжээ авч ажилласан.

Мөн 2019 он 2020 оны эхний улирлын аймгийн эрүүгийн нөхцөл байдлын танилцуулга мэдээллийг аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд хэлэлцүүлж Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, эрх зүйн дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2020 оны төлөвлөгөөг баталж сумд, агентлаг, байгууллагуудад хүргүүлсэн.

2020 оны 03 дугаар сарын 31-ний өдрөөс мөн оны 04 дүгээр сарын 30-ны өдөр хүртэл хугацаанд аймгийн Засаг даргын А/191 дүгээр захирамжаар согтууруулах ундаагаар үйлчлэх цагийн хязгаарлалтыг богиносгож өөрчлөлт оруулсан хяналт тавьж ажиллаж байна.

Дөрөв. Боловсрол, соёл, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын бодлогын хүрээнд:

Цахим номын сан 5 сургуульд /Тариалан, Чандмань-Өндөр, Цэцэрлэг, Жаргалант, Сод-Эрдэм/ нийлүүлж, программ хангамжийн ашиглах арга зүйн сургалтыг явууллаа. Тус цахим номын сангийн нэг бүрийн үнэ 8,5 сая бөгөөд үүнд РС, бар код уншигч, цахим уншигч, программ хангамж багтсан, нийт 42,5 сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг хийлээ.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралд “Иргэдийн оролцоонд тулгуурлсан соёлын өв хамгаалал” хөтөлбөрийг 3 сарын 20 ны өдөр оруулж батлууллаа.

Хорио цээр тогтоосонтой холбогдуулан 2020 оны мэргэжил дээшлүүлэх үндсэн сургалтыг онлайн хэлбэрээр зайн сургалтаар зохион байгуулах тухай Засгийн газрын тогтоол болон БСШУС-ын сайдын тушаалын хэрэгжилтийг хангах хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны талаар БМДИ-ээс аймаг, дүүргийн БСУГ, хэлтсийн удирдлагууд /дарга, хэлтсийн дарга, ахлах мэргэжилтэн оролцоно/-д мэдээлэл өгөх,

санал солилцох зорилгоор 2020 оны 03 дугаар сарын 23-ны өдөр /Даваа гараг/ видео хурал зохион байгуулах тул видео хурал хийлээ.

ЭШ—ын Цахим сорилго 2020 бүртгэл хийгдсэн. 30 сургуулийн 1050 хүүхэд бүртгэлд хамрагдсан. Туршилт 20-22 –ны өдрүүдэд явагдлаа.

1. Шинэ коронавирусын халдвараас ард иргэдээ хамгаалах, урьдчилан сэргийлэх, онцгой нөхцөлд ажиллаж байгаа төрийн ажилтан албан хаагчдадаа дэм болох, өвөлжилт, хаваржилт хүндрэлтэй байгаа сумын малчдадаа туслах зорилгоор аймгийн хэмжээнд зарлагдсан “Итгэл, Сэтгэл” аянд Хөвсгөл аймгийн Боловсрол, соёл, урлагийн салбарын байгууллагуудаас -28.937.600 төгрөгийн мөнгөн тусламж, 17.913.400 төгрөгийн бараа бүтээгдэхүүний тусламж үзүүлсэн байна.

2. Теле хичээлийн хэрэгжилт:


Дүгнэлт: Дээрх хугацааны тв хичээлд хамрагдалтын дундаж үзүүлэлт 74.8 % байна.

02.03-21	02.24-28	03.02-06	03.09-13	Дундаж
85%	72%	71,9%	70.3%	74,8%

Хугацааний эхэн хэсгийн хамрагдалтын байдлыг сүүлийн хугацаатай харьцуулж үзэхэд сурагчдын тв хичээлд хамралтын байдал 14,7 орчим хувиар буурсан

үзүүлэлттэй байна.

Сургуулийн өмнөх боловсрол: Бага насны хүүхдийн тв хичээлд хамрагдалтын тоон үзүүлэлтийг 2 дугаар сарын 17-ны өдрөөс 03-р сарын 13 –хүртлэх хугацаанд авч үзлээ.



ТВ хичээлд хамрагдалтын хувь: Дээрх хугацаанд дундажаар нийт цэцэрлэгийн багачуудын 67,7% нь тв хичээлд хамрагдсан бөгөөд

хугацааны төгсөлд хамралтын хувь буурсан үзүүлэлттэй байна.

Эрүүл мэндийн чиглэлээр

“ХҮҮХЭД-ИТГЭЛИЙН ХАРЦ” аянд нэгдэж Эрүүл мэндийн газрын дэргэдэх эцэг эхийн зөвлөлөөс хэрэгжүүлсэн ажлын тайланг 5 дахь өдөр болгон Эмнэлгийн тусламж үйлчилгээний хэлтсийн хүүхдийн мэргэжилтэнд хүргүүлэн ажиллаж байна. Өнөөдрийн байдлаар “Эцэг , эх”-ийн зөвлөл раге хуудсанд 35 төрлийн мэдээллийг байршуулан ажиллаж байна.

Дэлхийн эмч нарын өдрийг угтан “Эмчдээ баярлалаа” цахим талархлын 7 хоногийн хугацаатай аян зохион байгуулагдаж байна. Аяны хүрээнд талархлын мэндчилгээ-1241, захидал-6, байгууллага хамт олонд хандсан мэндчилгээ-42 хүлээн авсан байна. Өнөөдрийн байдлаар 12 сумын эрүүл мэндийн төв тайлангаа ирүүлээд байна

Хөдөлмөр, халамжийн чиглэлээр

Нийгмийн халамжийн тухай хуулийн дагуу амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой буюу өрхийн мэдээллийн санд бүртгэлтэй, 609-с доош босго оноотой 2745 өрхийн 7076 хүүхэд, 7650 том хүн буюу нийт 14726 иргэнд хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх халамжийн үйлчилгээг 2020 онд үзүүлнэ. Тус иргэдэд үйлчилгээ үзүүлэх аж ахуйн нэгж, байгууллагыг сонгон шалгаруулж, гүйцэтгэлийн гэрээг 51 аж ахуйн нэгжтэй байгуулах ажлыг зохион байгууллаа. Тус үйлчилгээг үзүүлэхэд 2,3 тэрбум төгрөгийн санхүүжилтийг нийгмийн халамжийн сангаас санхүүжүүлнэ.

3-р сард 128 иргэн ажилд зуучлагдаж, 617 иргэн идэвхитэй ажил хайгчаар бүртгэгдсэн бол 200 байнгын болон түр ажлын байр шинээр бий болсон байна.

2014-2017 онуудад ХЭДС-ийн санхүүгийн дэмжлэгт хамрагдсан иргэдийн эргэн төлөлтийн байдалд хяналт шалгалт хийж ажилласнаар ХЭДС-ийн дансанд 58.1 сая төгрөгийг төвлөрүүлсэн.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын чиглэлээр:

Хүүхэд хамгааллын мэргэжлийн ангиас байгууллагын ажилтан албан хаагчдад коронавирусээс урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдээллийг тухай бүр өгч, байгууллагын ажилтан албан хаагчдын фэйсбүүк групп чатаар мэдээллээ солилцож, тусгай горимд ажиллах хуваарийн дагуу хариуцлагатай жижүүрлэн ажиллаж өдөр бүр аймгийн ЭМГ байрлах Төв шуурхай штабт 16 цагт мэдээллэн ажиллаж байна. 3-р сард Хүүхдийн ордноор нийт 179 хүн гаднаас үйлчилгээ авсан байна.

Хүүхэд хамгааллын мэргэжлийн ангийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд туссаны дагуу байгууллагын дэргэдэх “Нэг цэгийн үйлчилгээний төв”-ийг бэлэн байдалд шилжүүлж, нөөц бүрдүүлэх ажлыг хэрэгжүүлж байна. Уг ажлын хүрээнд тус төвд байрлаж байгаа хүүхдүүдэд хэрэглэгдэх 500000 төгрөгний хүүхдийн тоглоомыг, хүүхэд насанд хүрэгчдэд зориулсан 1000000 төгрөгийн номыг тус тус худалдан авч, хүлээлгэн өглөө.

ГБХЗХГ-ын даргын 2020 оны А/24 дүгээр тушаал 2020 оны 01/104 дүгээр албан бичгээр ирүүлсэн чиглэлийн дагуу “Хүүхэд хамгааллын эрсдэлийг тодорхойлох, зураглал гаргах үнэлгээ хийх ажлын удирдамж”-ийг хэрэгжүүлж 2020 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн байдлаар 24 суманд эрсдэлтэй гэж тогтоогдсон 1988 өрхийн мэдээлэл бүртгэгдсэн “хүүхдийн эрсдэлийн түргэвчилсэн үнэлгээ” хийх ажил үргэлжлэн явагдаж байна.

3 дугаар сарын 3-аас 9-ний өдрийн хугацаанд Мөрөн хотоос Улаанбаатар хотын чиглэлд 15, 18 цагт 13 автобусанд 93 хүүхэд, 1066 насанд хүрэгч зорчиж, иргэдэд болон жолооч нарт зөвлөмж, мэдээлэл хүргэж, 850 ширхэг зөвлөмжийг тараан, иргэдэд амны хаалтаа байнга зүүж байхыг зөвлөв.

“Хүүхэд итгэлийн харц” аяны хүрээнд “Коронавирусний халдвараас хамтдаа сэргийлж хайртай бүхнээ хамгаалъя” гар зураг, зохион бичлэг, эсээ бичвэр, “I can” цахим контентын 2 төрлийн уралдааныг хүүхэд, залуучуудын дунд зохион байгуулж

байна. Уг уралдаанд 6-12-р ангийн 14 хүүхэд, 2 оюутан залуучууд бүртгүүлсэн байна. “Коронавирусний халдвараас хамтдаа сэргийлж хайртай бүхнээ хамгаалъя” цахим гар зураг, зохион бичлэг, эсээ бичлэгийн уралдаанд нийт 400 гаруй хүүхэд багачууд бүтээлээ ирүүлсэн. Уралдааны шалгаруулалтыг ажлын хэсэг дүгнэнэ.

Цахим орчинд явуулсан мэдээллийн дагуу өнөөдрийн байдлаар 4 сайн дурын ажилтан бүртгэгдээд байна. Мөн 23 сумын залуучуудын салбар зөвлөлөөр дамжуулан малчин залуучуудад 6 төрлийн 920 ширхэг зөвлөмжийг хүргүүлэн ажиллалаа.

Соёлын чиглэлээр:

Хөгжимт драмын театрын эцэг эхийн зөвлөл нь Совид – 19 короновирустай холбогдуулан хүүхдийнхээ дархлааг сайжруулах зорилгоор 03 дугаар сард байгууллагын нийт ажиллагсад 64 хүнд витамин, 55 өрхөд гарын шингэн саван өгөх ажлыг зохион байгууллаа.

Соёлын төв чанартай үйлчилгээ-4 уралдааныг аймгийн хэмжээнд зохион байгуулж дүгнэн МУ-ын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл урлагийн газарт эхний байруудад орсон Бүрэнтогтох сум, Чандмань-Өндөр, Рашаант , Цагаан-Үүр, сумдын материалыг цахим болон цаасаар хүргүүллээ.

Тав. Хөдөө аж ахуйн бодлогын хүрээнд:

Улс, аймгийн онцгой комисс, аймгийн шуурхай штабад хүн амын гол нэрийн бүтээгдэхүүний хангамжийн тооцоололыг сум бүрээр жишсэн хүн амаар тооцон хүргүүлсэн. Хүнс, Хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яамнаас ирүүлсэн үүрэг чиглэлийн дагуу хүнсний боловсруулах салбарын үйлдвэрүүд, агуулах, худалданы цэг салбаруудад байгаа хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний бодит үлдэгдэлийн мэдээг долоо хоног бүрийн Баасан гарагт хүргүүлж ажиллаа.

2020 оны 03 дугаар сарын 27-ны байдлаар 23 сум нэг тосгоноос хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний судалгааг авч нэгтгэхэд сум орон нутгийн худалдаа үйлчилгээний цэг салбар, хүнсний боловсруулах үйлдвэрүүдэд мах 356,3 тн буюу 27 хоног, гурил 562,2 тн 52 хоног, гурилан бүтээгдэхүүн 47,8 тн 2 хоног, төрөл бүрийн будаа 88,04 тн, төмс 80,8 тн, хүнсний ногоо 51,7 тоннын үлдэгдэлтэй байна.

Мах боловсруулах үйлдвэрүүдэд 63 тн, хөргүүртэй зориудад 174,4, сум орон нутгийн худалдаа үйлчилгээний цэгүүдэд 48,7 тн махны үлдэгдэл байна.

“Хөвсгөл Алтан-Дуулга” ХХК –д 172,9 тн гурил, товарын /гурил үйлдвэрлэх зориулалтын/ улаанбуудай 370 тн, сум орон нутгийн хүнсний дэлгүүр, худалдаа үйлчилгээний цэг салбарууд болон хүнсний захуудад 389,3 тн гурилын үлдэгдэлтэй байна.

Газар тариалангийн салбарын аж ахуйн нэгжүүдийн хаврын тариалалтанд шаардлагатай үр, ургамал хамгааллын бодис, бордооны захиалгыг авч нэгтгэн Хөдөө аж ахуйн дэмжх санд хүргүүллээ. Мөн 2020 оны тариалах талбай, уринш хийх талбайн судалгаа, хашаажуулсан болон ойн зурвас байгуулсан талбайн судалгаа, дутагдах үрийн судалгаа зэргийг ХХААХҮЯ-ны ГТХБЗГ-т хүргүүлэв.

ХХААХҮЯ-наас албан тоотой ирүүлсэн хариутай бичгийн дагуу аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй нийтийн хоолны газрууд, аймгийн төвийн томоохон хоолны газруудад хэрэглэгдэж буй түүхий эдийн судалгааг гаргаж хугацаанд нь хүргүүлсэн.

Төл бойжилтын талаар: Аймгийн хэмжээнд 2020 оны 03 сарын 26-ны байдлаар оны эхний 2689,6 мянган толгой хээлтэгч мал төллөхөөс нийт 109311 толгой хээлтэгч төлөлснөөс ингэ 10, гүү 183, үнээ 2555, эм хонь 79740, эм ямаа 26823 мал төллөж байна. Нийт 100453 толгой төл бойжиж үүнээс ботго 10, унага 162, тугал 2436, хурга 74242, ишиг 23603 толгой байна. Нийт төллөх хээлтэгч малын 5,7 хувь төллөлсөн, төл бойжилт 91,9 хувьтай байна.

Мал хорогдлын талаар: 23 сум нэг тосгоны 7027 малчин өрхийн 166721 толгой мал хорогдсоноос тэмээ 2, адуу 5262, үхэр 11859, хонь 86438, ямаа 63160 толгой мал буюу оны эхний нийт малын 2,8 хувь хорогдсон байна.

-Жаргалант суманд 5 багийн 1034 өрхийн 43663 толгой мал хорогдсоноос адуу 2045, үхэр 2765, хонь 22882, ямаа 13164 толгой мал буюу сумын оны эхний нийт малын 14,9 хувь хорогдсон байна.

-Галт суманд 5 багийн 1007 өрхийн 29332 толгой мал хорогдсоноос адуу 1192 толгой, үхэр 2066 толгой, 13901 хонь, ямаа 12173 толгой мал буюу сумын оны эхний нийт малын 7,2 хувь хорогдсон байна.

-Шинэ-Идэр суманд 4 багийн 514 өрхийн 23601 толгой мал хорогдсоноос адуу 753, үхэр 2133, хонь 14631, ямаа 6084 толгой мал буюу сумын оны эхний нийт малын 10,1 хувь хорогдсон байна.

-Цэцэрлэг суманд 7 багийн 713 өрхийн 19206 толгой мал хорогдсоноос адуу 292, үхэр 745, хонь 8159, ямаа 10010 толгой мал буюу сумын оны эхний нийт малын 6,2 хувь хорогдсон байна.

Аймгийн нөөцөд нийт 267тн өвс, 38тн тэжээл байна. Сумын нөөцийн өвсийг хэрэглээд дууссан. Сүүлд хуваарилсан Улсын нөөцөөс 27,2тн өвс байгааг сумдад хүргүүлэх ажлыг зохион байгуулж байна.

Ариутгал халдваргүйжүүлэлтийн ажлын талаар: Аймгийн Засаг даргын 2020 оны 2-р сарын 27-ны А/122 захирамжаар 11 сумын хэмжээнд 28 зоорь, 232 малын хашаа, 15 худаг, 1 тэжээлийн агуулах, 10 тээврийн хэрэгсэл, 1 түүхий эд бүтээгдэхүүний хадгалах цэг, 18481 сэг зэм, нийт 46851 м² талбайг ариутгаж 6324,5 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Зургаа.Байгаль орчин, үйлдвэрлэл үйлчилгээ, дэд бүтцийн салбарын бодлогын хүрээнд:

Аймгийн хэмжээнд мөрдөх нийтийн эдэлбэр газрын хог хаягдлыг цэвэрлэх, энгийн хог хаягдлыг булшлах зардлын нэгж тарифыг боловсруулж, аймгийн Засаг даргын зөвлөл, ИТХТ-ээр хэлэлцүүлээ.

Химийн гаралтай аюултай хаягдлын зориулалтын агуулах байгуулах газрын гэрчилгээ, зураг, цахилгааны эх үүсвэр татах техникийн нөхцөлийг хийж, 2020 онд БОАЖЯ-ны санхүүжилтээр агуулах баригдахаар шийдвэрлэгдсэн.

Ойн болон усны сан бүхий газрын хог хаягдлын менежментийг сайжруулах, эзэнгүй хог хаягдлыг цэвэрлэх, хог хаягдлыг ангилах ажлыг гүйцэтгүүлэх иргэдийн бүлэгт дэмжлэг үзүүлэх ажлын хүрээнд аймгийн Засаг даргын 2020 оны 103 дугаар захирамжийн дагуу 6 суманд гэрээг хүргүүлж, санхүүжилтийг шилжүүлж байна.

Уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг иргэдийн анхаарлыг хандуулах зорилго бүхий “Эх дэлхийн цаг 60+” арга хэмжээ нь цаг үеийн байдлаас шалтгаалан цуцлагдсан тул цахимаар олон нийтэд мэдээлэл өгч, сурталчилгаа хийж ажиллав.

Дэд бүтцийн салбар:

2020 оны 3 сарын 27-ны өдрийн байдлаар аймгийн хэмжээнд газрын эзэмших эрхийн гэрээ гэрчилгээг банк болон банк бус санхүүгийн байгууллагад нийт 1548 иргэн, аж ахуйн нэгж байгууллага бүртгүүлсэн бөгөөд үүнээс өмнөх үлдэгдэл 1345, барьцаанаас чөлөөлөгдсөн 0, шинээр нэмж бүртгэсэн 203 иргэн, аж ахуйн нэгж байгууллагын гэрээ гэрчилгээг газрын цахим биржийн системд бүртгэн баталгаажуулсан. Үүнээс газар өмчлөгч 76, эзэмшигч эрхийн 1280, үүнээс аж ахуйн нэгж байгууллага 97, иргэний 1112-н барьцаа бүртгэгдээд байгаа ба хоосон газар 920, үл хөдлөх хөрөнгө бүхий 447 газар, гэр бүлийн хэрэгцээний зориулалттай газар 1012, худалдаа үйлчилгээний зориулалттай газар 232, үйлдвэрийн газар 13, хөдөө аж ахуйн 121 газрууд тус тус барьцаанд бүртгэгдсэн байна. Барьцаанд тавигдсан мэдээгээр ХААН банкинд хамгийн их буюу 1104, төрийн банкинд 112, голомт банкинд 79, худалдаа хөгжлийн банкинд 4, төрийн сан банк 18, хас банкинд 108, капитрон банкинд 1, бусад буюу банк бус санхүүгийн байгууллагад 103, иргэнээс иргэнд газар эзэмших эрхийн гэрчилгээгээ барьцаалсан мэдээ 10 байна.

2. Газрын төлбөр ногдуулалт, төлөлт

2020 онд аймгийн хэмжээнд Газрын төлбөр 245,0 сая төг, дуудлага худалдаа 370,0 сая төгрөгийн төлөвлөгөөг аймгийн ИТХ-ын 2019 оны 12 сарын 5-ны өдрийн №02 тоот тогтоолоор баталсны дагуу хэрэгжүүлж ажиллаж байна.

2020 оны аймгийн хэмжээнд нийт 245.0 сая төгрөгийг газрын төлбөрийн орлого төсөвт төвлөрүүлэх төлөвлөгөөтэй байснаас 41.057.3 сая төгрөгийн орлогыг улсын төсөвт төвлөрүүлсэн.

Газрын албан татвар төлөлтийн ГТМ-3 тайлангийн маягтаар аймгийн хэмжээнд нийт 14010 иргэнд 1371,3 га газрыг өмчлүүлсэн ба уг өмчлүүлсэн газрын татварын ногдуулсан 3112721,8 төгрөгийн мэдээ судалгааг гаргасан Татварын удирдлагын дундын систем нэвтрүүлэхээр ажиллаж байна.

Долоо. Цаг үеийн бусад мэдээлэл:

Засгийн газрын 2020 оны 30 дугаар тогтоолын дагуу төрийн байгууллагууд нийт албан хаагчдын 0-12 насны хүүхдүүдийн судалгааг гарган ажлын цагийн зохицуулалт хийж хүүхдүүдээ асран хамгаалах боломжоор ханган ажиллаж байна.

Аймгийн Онцгой комиссийн шийдвэрийн дагуу Мөрөн сумын зочид буудлууд, сумдаас гадаадын жуулчдын мэдээлэл авч аймгийн Онцгой комиссын шуурхай штабыг мэдээллээр хангах ажлыг зохион байгуулж байна.

Аймгийн төвд үйл ажиллагаа явуулдаг Бишрэлт, 50,100, Эйделвайс, Эвент Холл зочид буудал, Сараа гэст хаус, Mountaun guev гэр буудал, Цагааннуур, Ханх, Улаан-Уул, Рэнчинлхүмбэ, Цагаан-Үүр, Чандмань-Өндөр, Алаг-Эрдэнэ,Түнэл, Арбулаг, Баянзүрх, Эрдэнэбулган сум, Хатгал тосгоныг хариуцан ажиллаж мэдээ, мэдээллийн шуурхай байдлыг хангаж аймгийн Онцгой комиссын шуурхай штабад мэдээлэл хүргүүлэн ажиллаж байна.

Хөвсгөл аймагт МУЗГ-аас онцгой дэглэм тогтоож, хөл хорио тогтоохоос өмнө болон, түүнээс хойш орж ирсэн гадаадын иргэд, жуулчдын мэдээллийг тухай бүр нь гаргаж аймгийн шуурхай штабын shun khuvsgul@gmail.com хаягаар хүргүүлж, тэдгээртэй холбоотой мэдээллийг ТЕГ-ын харьяа Тагнуулын хэлтэс, аймаг дахь Гадаадын иргэн харьяатын асуудлыг хариуцсан ажилтан, аймгийн Цагдаагийн газруудтай хамтран ажиллаж мэдээлэл харилцан солилцож мэдээллийн нэгдмэл байдлыг ханган судалгааг хүргүүлж тухай бүр нь мэдээлэн ажиллаж байна.

2020 оны 03 дугаар сарын 30-ны байдлаар Австри улсын 2 иргэн Мөрөн сумын 50,100 зочид буудалд байрлаж байна, бусад гадаадын иргэд нутаг буцсан байна.